ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

## САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАНГИЙН АУДИТ

---

Өмнөговь аймгийн Цогт-Овоо сумын Засаг даргын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

**Аудитын код:** ӨМА-2026/013/НА-СТА-ТТЗ

| | |
|---|---|
| Цахим хуудас: www.audit.mn<br>Даланзадгад хот<br>2026 он | Өмнөговь аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: Ц.Өсөхбаяр<br>Утас: 70533539 Цахим хаяг: usukhbayarts@audit.gov.mn<br>Аудитын менежер: Т.Хонгорзул<br>Утас: 70533552 Цахим хаяг: Khongorzult@audit.gov.mn<br>Ахлах аудитор: Ж.Болормаа<br>Утас: 70533552 Цахим хаяг: bolormaaja@audit.gov.mn<br>Аудитор: Э.Жаргал<br>Утас: 70533552 Цахим хаяг: jargale@audit.gov.mn |

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## 1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ

ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
Нутгийн удирдлагын ордон 304 тоот, 3 дугаар баг,
Даланзадгад сум, Өмнөговь аймаг, 46083
Утас: (976) 7053 3539, Цахим хуудас: www.audit.mn
Цахим шуудан: umnugovi@audit.gov.mn

2026.03.25 № 345

танай ______________-ны №______________ -т

ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ЦОГТ-ОВОО
СУМЫН ЗАСАГ ДАРГА
Н.НАРАНЗАЯА ТАНАА

### Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Өмнөговь аймгийн Цогт-овоо сумын Засаг даргын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

### Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу хараат бусаар гүйцэтгэж, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Орон нутгийн нөөц сангаас уралдаан тэмцээн зохион байгуулахад хөрөнгө зарцуулсан, хөтөлбөр арга хэмжээний зардлаас хуулиар хориглосон арга хэмжээ зохион байгуулсан, анхан шатны баримтаар нотлогдохгүй, ажил гүйлгээ санхүүжүүлсэн, төсвийн хөрөнгийг зориулалт бусаар зарцуулсан зэрэг зөрчлүүд нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд дангаар буюу нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй байна.

Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2, 5.1.5, 6 дугаар зүйлийн 6.4.1, 6.4.2, 24 дүгээр зүйлийн 24.5, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.2, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, 13 дугаар зүйлийн 13.1, 13.5, 20 дугаар зүйлийн 20.2.3, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.1.8 дахь Сангийн сайдын 2021 оны 61 дугаар тушаалаар баталсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын журам"-ын 1.2, 6.1, 6.5, 7.1 дэх заалтуудтай нийцээгүй бөгөөд санхүүгийн тайлагналын эрх ба үүрэг, ангилал, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

4626050540

**Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг**

Тайлант онд "Говийн оюу" хөгжлийг дэмжих сангийн хөрөнгө оруулалтаар 1,683,302.2 мянган төгрөгийн ахмадын өргөөний барилга, тоног төхөөрөмжийг үнэ төлбөргүй хүлээн авч ашиглалтад оруулсан байна.

**Аудитын гол асуудал**

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны Б/01 дугаар тогтоолоор орон нутгийн төсвийн орлогыг 663,308.6 мянган төгрөгөөр төлөвлөснөөс гүйцэтгэлээр 810,116.4 мянган төгрөг төвлөрүүлсэн байна.

**Бусад асуудлын хэсэг**

Цогт-Овоо сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны 6/2 дугаар тогтоолоор 2025 оны хөгжлийн жилийн төлөвлөгөөний хэрэгжилтийг 94.5 хувийн биелэлттэй гэж дүгнэсэн байна. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ц.ӨСӨХБАЯР

# АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

## 2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан /мянган төгрөгөөр/

| Дансны нэр, төрөл | Тодруулга | 2024 оны 12-р сарын 31 | 2025 оны 12-р сарын 31 |
|---|---|---|---|
| 1. ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН | | 3,002,837.78 | 3,603,311.92 |
| 1.1.1 МӨНГӨН ХӨРӨНГӨ | 3а, 3б | 1,291,012.28 | 1,851,511.93 |
| 1.1.3 АВЛАГА | 5а, 5б, 6а, 6б | 414,642.59 | 677,200.01 |
| 1.1.5 БАРАА МАТЕРИАЛ | 8а, 8б, 8в | 1,226,460.41 | 1,045,759.69 |
| 1.1.6 НӨӨЦИЙН БАРАА | 9а | 70,722.50 | 28,840.30 |
| 1.2 ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН | | 20,554,836.21 | 23,185,834.51 |
| 1.2.2 ҮНДСЭН ХӨРӨНГӨ | 12а, 12б, 12в | 20,554,836.21 | 23,185,834.51 |
| 1.2.2.02 Биет хөрөнгө | | 20,246,703.36 | 22,877,998.56 |
| 1.2.2.03 Биет бус хөрөнгө | 13 | 308,132.85 | 307,835.95 |
| 1 НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН 3=1+2 | | 23,557,673.99 | 26,789,146.44 |
| 2.1 НИЙТ ӨР ТӨЛБӨР | | 8,652,531.97 | 9,601,827.44 |
| 2.1.1 БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР | | 338,668.44 | 468,316.81 |
| 2.1.1.03 Өглөг | | 175,184.71 | 197,178.84 |
| 2.1.1.04 Урьдчилж орсон орлого | 18а, 18б | 163,483.73 | 271,137.97 |
| 2.1.2 УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР | | 8,313,863.53 | 9,133,510.63 |
| 2.1.2.02 Урт хугацаат зээл | 20а, 20б | 8,313,863.53 | 9,133,510.63 |
| 2.2 ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН | | 14,905,142.03 | 17,187,319 |
| 2.2.1 Засгийн газрын хувь оролцоо | | 14,905,142.03 | 17,187,319 |
| 2.2.1.01 Засгийн газрын оруулсан капитал | | 948,837.72 | 948,837.72 |
| 2.2.1.08 Хуримтлагдсан үр дүн | | 13,896,056.45 | 16,178,233.42 |
| 2.2.1.09 Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | | 60,247.85 | 60,247.85 |
| 2 ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН 6=4+5 | | 23,557,673.99 | 26,789,146.44 |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан /мянган төгрөгөөр/

| Дансны нэр, төрөл | Тодруулга | 2024 оны 12-р сарын 31 | 2025 оны 12-р сарын 31 |
|---|---|---|---|
| 1.1.1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН | | 12,148,392.01 | 9,342,336.59 |
| 1.1.1.03 ТАТВАРЫН ОРЛОГО | | 638,928.38 | 688,933.40 |
| 1.1.1.03.1 Орлогын албан татвар | | 506,269.83 | 563,877.02 |
| 1.1.1.03.1.01 Хувь хүний орлогын албан татвар | | 536,269.83 | 595,940.22 |
| 1.1.1.03.1.02 Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт | | -30,000 | -32,063.2 |
| 1.1.1.03.3 Хөрөнгийн албан татвар | | 54,522.57 | 29,989.21 |
| 1.1.1.03.8 Бусад татвар, төлбөр, хураамж | | 78,135.97 | 95,067.17 |
| 1.1.1.04 ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 1а, 1б | 6,244,020 | 8,653,403.18 |
| 1.1.1.04.3 Тусламжийн орлого | | - | 5,068,929.82 |
| 1.1.1.05 ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | | 5,265,443.64 | - |
| 1.1.2 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН | 2а, 2б | 5,693,244.28 | 5,087,057.56 |
| 1.1.2.01 УРСГАЛ ЗАРДАЛ | | 5,693,244.28 | 5,087,057.56 |
| 1.1.2.01.1 БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | | 4,873,352.28 | 4,528,143.30 |
| 1.1.2.01.1.01 Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | | 1,023,396.59 | 1,295,522.30 |
| 1.1.2.01.1.02 Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | | 122,746.17 | 158,834.88 |
| 1.1.2.01.1.03 Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | | 656,449.57 | 677,899.41 |
| 1.1.2.01.1.04 Хангамж, бараа материалын зардал | | 95,048.78 | 404,587.08 |
| 1.1.2.01.1.05 Нормативт зардал | | 350.00 | 877.30 |
| 1.1.2.01.1.06 Эд хогшил, урсгал засварын зардал | | 86,962.25 | 110,779.86 |
| 1.1.2.01.1.07 Томилолт, зочны зардал | | 21,986.00 | 13,780.00 |
| 1.1.2.01.1.08 Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | | 388,430.55 | 446,413.08 |

| | | | |
|---|---|---|---|
| 1.1.2.01.1.09 Бараа үйлчилгээний бусад зардал | | 2,477,982.37 | 1,419,449.39 |
| 1.1.2.01.3 ТАТААС | | 15,0000.00 | - |
| 1.1.2.01.4 УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | | 804,892.01 | 558,914.27 |
| 1.1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II) | | 6,455,147.73 | 4,255,279.02 |
| 1.2.2 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН | | 93,165.00 | 1,973,102.05 |
| 1.2 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (VII)=(IV)-(V) | | -93,165.00 | -1,973,102.05 |
| 1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(VII) | | 6,361,982.73 | 2,282,176.97 |

## 2.3 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан /мянган төгрөгөөр/

| Дансны нэр, төрөл | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн | Нийт цэвэр хөрөнгө /өмч |
|---|---|---|
| 1.1.1.1.1.1 2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 8,543,159.30 | 8,543,159.30 |
| 1.1.1.1.1 Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 8,543,159.30 | 8,543,159.30 |
| 1.1.1.1.7 Тайлант үеийн үр дүн | 6,361,982.73 | 6,361,982.73 |
| 1.1.1.1 2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 14,905,142.03 | 14,905,142.03 |
| 1.1.1 2025 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл | 14,905,142.03 | 14,905,142.03 |
| 1.1 Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 14,905,142.03 | 14,905,142.03 |
| 1.7 Тайлант үеийн үр дүн | 2,282,176.97 | 2,282,176.97 |
| 1 2025 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл | 17,187,319 | 17,187,319 |

## 2.4 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан /мянган төгрөгөөр/

| Дансны нэр, төрөл | 2024 оны 12-р сарын 31 | 2025 оны 12-р сарын 31 |
|---|---|---|
| 1.1.1.1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН | 7,253,953.11 | 8,257,731.71 |
| 1.1.1.1.03 ТАТВАРЫН ОРЛОГО | 638,928.38 | 688,933.40 |
| 1.1.1.1.03.1 Орлогын албан татвар | 506,269.83 | 563,877.02 |
| 1.1.1.1.03.1.02 Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт | -30,000.00 | -32,063.20 |
| 1.1.1.1.03.3 Хөрөнгийн албан татвар | 54,522.57 | 29,989.21 |
| 1.1.1.1.03.8 Бусад татвар, төлбөр, хураамж | 78,135.97 | 95,067.17 |
| 1.1.1.1.03.8.01 Бусад нийтлэг төлбөр, хураамж | 25,723.64 | 22,747.50 |
| 1.1.1.1.03.8.02 Газрын төлбөр | 7,354.09 | 11,894.66 |
| 1.1.1.1.03.8.03 Байгалийн нөөц ашигласны төлбөр | 45,058.24 | 60,425.01 |
| 1.1.1.1.04 ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 1,291,093.95 | 7,568,798.31 |
| 1.1.1.1.04.1 Нийтлэг татварын бус орлого | 1,291,093.95 | 1,514,041.65 |
| 1.1.1.1.04.3 Тусламжийн орлого | - | 5,298,083.26 |
| 1.1.1.1.04.4 Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг | - | 756,673.40 |
| 1.1.1.1.05 ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 5,323,930.79 | - |
| 1.1.1.2 НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 5,554,932.80 | 5,565,298.68 |
| 1.1.1.2.01 УРСГАЛ ЗАРДАЛ | 5,554,932.80 | 5,565,298.68 |
| 1.1.1.2.01.1 БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 4,622,197.67 | 4,342,631.68 |
| 1.1.1.2.01.1.01 Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 1,331,273.71 | 1,802,372.40 |
| 1.1.1.2.01.1.02 Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 229,047.79 | 299,676.61 |
| 1.1.1.2.01.1.03 Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 720,445.24 | 768,986.12 |
| 1.1.1.2.01.1.04 Хангамж, бараа материалын зардал | 319,502.96 | 548,633.42 |
| 1.1.1.2.01.1.05 Нормативт зардал | 4,250.00 | 877.30 |
| 1.1.1.2.01.1.06 Эд хогшил, урсгал засварын зардал | 89,586.25 | 120,258.86 |
| 1.1.1.2.01.1.07 Томилолт, зочны зардал | 21,986.00 | 13,780.00 |
| 1.1.1.2.01.1.08 Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 346,203.84 | 339,150.28 |
| 1.1.1.2.01.1.09 Бараа үйлчилгээний бусад зардал | 1,559,901.88 | 448,896.69 |
| 1.1.1.2.01.3 ТАТААС | 15,000.00 | - |
| 1.1.1.2.01.4 УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 917,735.13 | 1,222,666.99 |
| 1.1.1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II) | 1,699,020.31 | 2,692,433.03 |
| 1.1.2.2 ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН | 803,334.01 | 2,131,933.38 |
| 1.1.2.2.01 ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ | 803,334.01 | 2,131,933.38 |
| 1.1.2.2.01.1 Дотоод эх үүсвэрээр | 803,334.01 | 2,131,933.38 |
| 1.1.2 ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V) | -803,334.01 | -2,131,933.38 |
| 1.1 НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII) | 895,686.3 | 560,499.66 |
| **1.2 Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | 395,325.97 | 1,291,012.28 |

| | | |
|---|---|---|
| **1 Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | 1,291,012.28 | 1,851,511.93 |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан /мянган төгрөгөөр/

| Дансны нэр, төрөл | Төлөвлөгөө | Гүйцэтгэл |
|---|---|---|
| 3.1.01.1 НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН | 4,390,576.20 | 3,967,784.55 |
| 3.1.01.1.1 Татварын орлого | 573,216.80 | 688,933.40 |
| 3.1.01.1.1.1 Орлогын албан татвар | 478,836.80 | 563,877.02 |
| 3.1.01.1.1.1.1 Хувь хүний орлогын албан татвар | 510,900.00 | 595,940.22 |
| 3.1.01.1.1.1.1.01 Цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлого | 400,000.00 | 497,078.69 |
| 3.1.01.1.1.1.1.02 Үйл ажиллагааны орлого | 15,000.00 | 12,372.21 |
| 3.1.01.1.1.1.1.03 Хөрөнгийн орлого | 55,900.00 | 45,172.15 |
| 3.1.01.1.1.1.1.04 Хөрөнгө борлуулсны орлого | - | 1,210.40 |
| 3.1.01.1.1.1.1.07 Шууд бус орлого | 40,000.00 | 40,106.77 |
| 3.1.01.1.1.1.2 Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт | (32,063.20) | (32,063.20) |
| 3.1.01.1.1.1.2.01 Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт | (32,063.20) | (32,063.20) |
| 3.1.01.1.1.3 Хөрөнгийн албан татвар | 17,380.00 | 29,989.21 |
| 3.1.01.1.1.3.1 Үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар | 6,280.00 | 4,985.01 |
| 3.1.01.1.1.3.2 Бууны албан татвар | 1,100.00 | 1,230.00 |
| 3.1.01.1.1.3.4 Малд ногдуулах албан татвар | 10,000.00 | 23,774.20 |
| 3.1.01.1.1.8 Бусад татвар, төлбөр, хураамж | 77,000.00 | 95,067.17 |
| 3.1.01.1.1.8.1 Бусад нийтлэг төлбөр, хураамж | 21,000.00 | 22,747.50 |
| 3.1.01.1.1.8.1.01 Улсын тэмдэгтийн хураамж | 9,000.00 | 12,057.50 |
| 3.1.01.1.1.8.1.06 Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр | 3,000.00 | 1,750.00 |
| 3.1.01.1.1.8.1.08 Хог хаягдлын үйлчилгээний хураамж | 9,000.00 | 8,940.00 |
| 3.1.01.1.1.8.2 Газрын төлбөр | 10,000.00 | 11,894.66 |
| 3.1.01.1.1.8.2.01 Газрын төлбөр | 10,000.00 | 11,894.66 |
| 3.1.01.1.1.8.3 Байгалийн нөөц ашигласны төлбөр | 46,000.00 | 60,425.01 |
| 3.1.01.1.1.8.3.02 Ан амьтны нөөц ашигласны төлбөр | 46,000.00 | 59,813.61 |
| 3.1.01.1.1.8.3.03 Ус, рашааны нөөц ашигласны төлбөр | - | 611.40 |
| 3.1.01.1.2 Татварын бус орлого | 3,817,359.40 | 3,278,851.15 |
| 3.1.01.1.2.1 Нийтлэг татварын бус орлого | 236,091.80 | 190,164.65 |
| 3.1.01.1.2.1.3 Торгуулийн орлого | 80,000.00 | 110,525.60 |
| 3.1.01.1.2.1.5 Төсөв байгууллагын өөрийн орлого /туслах/ | 156,000.00 | 79,639.05 |
| 3.1.01.1.2.1.7 Газрын тосны орлого | 91.80 | - |
| 3.1.01.1.2.3 Тусламжийн орлого | 2,824,594.20 | 2,332,013.10 |
| 3.1.01.1.2.3.3 Аймаг нийслэлээс авсан татаас | 2,824,594.20 | 2,332,013.10 |
| 3.1.01.1.2.4 Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг | 756,673.40 | 756,673.40 |
| 3.1.01.1.2.4.2 Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас шилжүүлсэн орлого | 756,673.40 | 756,673.40 |
| 3.1.01.2 НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 4,834,576.20 | 3,521,761.09 |
| 3.1.01.2.1 УРСГАЛ ЗАРДАЛ | 4,556,076.20 | 3,264,501.59 |
| 3.1.01.2.1.1 БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 3,281,634.80 | 2,598,765.38 |
| 3.1.01.2.1.1.1 Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 1,294,111.80 | 1,119,631.85 |
| 3.1.01.2.1.1.1.01 Үндсэн цалин | 527,128.00 | 496,793.65 |
| 3.1.01.2.1.1.1.02 Нэмэгдэл | 594,268.80 | 504,768.56 |
| 3.1.01.2.1.1.1.03 Унаа хоолны хөнгөлөлт | 69,500.00 | 51,993.36 |
| 3.1.01.2.1.1.1.04 Урамшуулал | 62,615.00 | 43,884.70 |
| 3.1.01.2.1.1.1.05 Гэрээт ажлын хөлс | 40,600.00 | 22,191.57 |
| 3.1.01.2.1.1.2 Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 161,644.00 | 138,327.56 |
| 3.1.01.2.1.1.2.01 Тэтгэврийн даатгал | 110,062.00 | 91,745.85 |
| 3.1.01.2.1.1.2.02 Тэтгэмжийн даатгал | 12,895.50 | 11,700.60 |
| 3.1.01.2.1.1.2.03 ҮОМШӨ-ний даатгал | 6,447.70 | 5,872.59 |
| 3.1.01.2.1.1.2.04 Ажилгүйдлийн даатгал | 6,447.70 | 5,606.54 |
| 3.1.01.2.1.1.2.05 Эрүүл мэндийн даатгал | 25,791.10 | 23,401.99 |
| 3.1.01.2.1.1.3 Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 848,584.70 | 668,904.22 |
| 3.1.01.2.1.1.3.01 Гэрэл, цахилгаан | 73,413.20 | 51,893.86 |
| 3.1.01.2.1.1.3.02 Түлш, халаалт | 758,571.50 | 605,603.36 |
| 3.1.01.2.1.1.3.03 Цэвэр, бохир ус | 16,600.00 | 11,407.00 |

| | | |
|---|---|---|
| 3.1.01.2.1.1.4 Хангамж, бараа материалын зардал | 277,603.80 | 262,783.75 |
| 3.1.01.2.1.1.4.01 Бичиг хэрэг | 8,156.40 | 5,810.80 |
| 3.1.01.2.1.1.4.02 Тээвэр, шатахуун | 56,900.00 | 50,336.45 |
| 3.1.01.2.1.1.4.03 Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 9,060.00 | 5,843.80 |
| 3.1.01.2.1.1.4.05 Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 197,822.40 | 197,822.40 |
| 3.1.01.2.1.1.4.06 Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 5,665.00 | 2,970.30 |
| 3.1.01.2.1.1.5 Нормативт зардал | 4,000.00 | 877.30 |
| 3.1.01.2.1.1.5.03 Нормын хувцас, зөөлөн эдлэл | 4,000.00 | 877.30 |
| 3.1.01.2.1.1.6 Эд хогшил, урсгал засварын зардал | 113,004.90 | 98,621.41 |
| 3.1.01.2.1.1.6.04 Урсгал засвар | 113,004.90 | 98,621.41 |
| 3.1.01.2.1.1.7 Томилолт, зочны зардал | 23,760.00 | 11,890.00 |
| 3.1.01.2.1.1.7.02 Дотоод албан томилолт | 23,760.00 | 11,890.00 |
| 3.1.01.2.1.1.8 Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 175,635.60 | 136,995.42 |
| 3.1.01.2.1.1.8.01 Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 175,635.60 | 136,995.42 |
| 3.1.01.2.1.1.9 Бараа үйлчилгээний бусад зардал | 383,290.00 | 160,733.87 |
| 3.1.01.2.1.1.9.01 Бараа үйлчилгээний бусад зардал | 371,500.00 | 153,570.92 |
| 3.1.01.2.1.1.9.02 Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 11,790.00 | 7,162.95 |
| 3.1.01.2.1.4 УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 1,274,441.40 | 665,736.21 |
| 3.1.01.2.1.4.1 Засгийн газрын урсгал шилжүүлэг | 1,232,673.40 | 640,010.21 |
| 3.1.01.2.1.4.1.01 Засгийн газрын дотоод шилжүүлэг | 1,232,673.40 | 640,010.21 |
| 3.1.01.2.1.4.1.03 Төсвийн санхүүжилт | - | - |
| 3.1.01.2.1.4.2 Бусад урсгал шилжүүлэг | 41,768.00 | 25,726.00 |
| 3.1.01.2.1.4.2.03 Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал | 800.00 | - |
| 3.1.01.2.1.4.2.04 Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 12,870.00 | 12,870.00 |
| 3.1.01.2.1.4.2.07 Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | 7,698.00 | 7,406.00 |
| 3.1.01.2.1.4.2.08 Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 20,400.00 | 5,450.00 |
| 3.1.01.2.2 ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ | 278,500.00 | 257,259.50 |
| 3.1.01.2.2.4 Бусад хөрөнгө | 278,500.00 | 257,259.50 |
| 3.1.01 ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ | (444,000.00) | 446,023.47 |
| 3.1 АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | 444,000.00 | (446,023.47) |
| 3 Харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт | 444,000.00 | (446,023.47) |
| 4 Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | - | 982,061.28 |
| 5 Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | - | 1,428,084.74 |

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан /мянган төгрөгөөр/

| Дансны нэр, төрөл | Тайлант он |
|---|---|
| 1.1.1.1 НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН | 2,966,070.16 |
| 1.1.1.1.1 ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 2,966,070.16 |
| 1.1.1.1.1.1 Тусламжийн орлого | 2,966,070.16 |
| 1.1.1.1.1.1.1 Хандив тусламж /дотоод/ | 2,966,070.16 |
| 1.1.1.1.1.1.1.1 Нэмэлт санхүүжилтийн орлого | 2,966,070.16 |
| 1.1.1.1.1.1.1.1.3 ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 2,403,270.78 |
| 1.1.1.1.1.1.1.1.4 Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 4,242.24 |
| 1.1.1.1.1.1.1.1.5 Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 558,557.14 |
| 1.1.1.2 НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 2,409,439.38 |
| 1.1.1.2.1 УРСГАЛ ЗАРДАЛ | 573,318.80 |
| 1.1.1.2.1.1 БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 573,018.80 |
| 1.1.1.2.1.1.1 Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 171,710.60 |
| 1.1.1.2.1.1.1.1 Үндсэн цалин | 20,098.08 |
| 1.1.1.2.1.1.1.4 Урамшуулал | 117,812.52 |
| 1.1.1.2.1.1.1.5 Гэрээт ажлын хөлс | 33,800.00 |
| 1.1.1.2.1.1.2 Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 21,415.43 |

| | |
|---|---|
| 1.1.1.2.1.1.2.1 Тэтгэврийн даатгал | 14,803.48 |
| 1.1.1.2.1.1.2.2 Тэтгэмжийн даатгал | 1,609.99 |
| 1.1.1.2.1.1.2.3 ҮОМШӨ-ний даатгал | 1,124.52 |
| 1.1.1.2.1.1.2.4 Ажилгүйдлийн даатгал | 600.32 |
| 1.1.1.2.1.1.2.5 Эрүүл мэндийн даатгал | 3,277.12 |
| 1.1.1.2.1.1.4 Хангамж, бараа материалын зардал | 22,003.05 |
| 1.1.1.2.1.1.4.1 Бичиг хэрэг | 2,896.80 |
| 1.1.1.2.1.1.4.2 Тээвэр, шатахуун | 18,719.75 |
| 1.1.1.2.1.1.4.6 Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 386.50 |
| 1.1.1.2.1.1.6 Эд хогшил, урсгал засварын зардал | 21,637.45 |
| 1.1.1.2.1.1.6.4 Урсгал засвар | 21,637.45 |
| 1.1.1.2.1.1.7 Томилолт, зочны зардал | 1,890.00 |
| 1.1.1.2.1.1.7.2 Дотоод албан томилолт | 1,890.00 |
| 1.1.1.2.1.1.8 Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 61,641.44 |
| 1.1.1.2.1.1.8.1 Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 61,641.44 |
| 1.1.1.2.1.1.9 Бараа үйлчилгээний бусад зардал | 272,720.83 |
| 1.1.1.2.1.1.9.1 Бараа үйлчилгээний бусад зардал | 270,705.83 |
| 1.1.1.2.1.1.9.2 Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 2,015.00 |
| 1.1.1.2.1.4 УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 300.00 |
| 1.1.1.2.1.4.2 Бусад урсгал шилжүүлэг | 300.00 |
| 1.1.1.2.1.4.2.8 Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 300.00 |
| 1.1.1.2.2 ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ | 1,836,120.58 |
| 1.1.1.2.2.1 Дотоод эх үүсвэрээр | 1,836,120.58 |
| 1.1.1.2.2.1.4 Бусад хөрөнгө | 1,836,120.58 |
| 1.1.1 ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ | 556,630.78 |
| 1.1 АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | (556,630.78) |
| 1 Харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт | (556,630.78) |

## 3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 2.0 сая төгрөгийн 1 алдаа[1] илэрснээс аудитын явцад 2.0 сая төгрөгийн 1 алдааг залруулсан. Үүнд:

- Хөтөлбөр, арга хэмжээний зардлаас 2.0 сая төгрөгийн "Эко 00"-ыг байгуулан хөрөнгийн бүртгэлд тусгалгүй зардлаар хүлээн зөвшөөрч тайлагнасан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д "үнэн зөв байх" 20 дугаар зүйлийн 20.2-д "Ерөнхий нягтлан бодогч дараах үүрэг хүлээнэ", 20.2.3-д "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах", санхүүгийн тайлангийн толилуулга батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Аудитаар нийт 56.4 сая төгрөгийн 6 зөрчил[2] илэрснээс 54.4 сая төгрөгийн 3 зөрчилд алдаа зөрчлийг таслан зогсож, давтан гаргахгүй байх 3 албан шаардлага, 2.0 сая төгрөгийн 3 зөрчилд хууль хэрэгжүүлэн ажиллах 3 зөвлөмж өгч ажилласан.

Нийт илрүүлсэн алдаа, зөрчлөөс залруулагдаагүй зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс 16.5 сая төгрөгөөр их тул “Хязгаарлалттай” дүгнэлт өглөө.

### 3.1 Төлбөрийн акт

Аудитын явцад төлбөрийн акт тогтоогоогүй.

---

[1] *Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,*
*1 Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.*

*2 Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.*

**3.2 Албан шаардлага**

***Илрүүлэлт 1:*** Орон нутгийн нөөц хөрөнгөөс зарцуулалт хийхдээ гүйцэтгэлийн ажлын тайлан, хөрөнгө зарцуулалтын тайлангүй 3.5 сая төгрөгийн санхүүжилт олгосон. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д "*үнэн зөв байх*", Сангийн сайдын 2021 оны 61 дугаар тушаалаар баталсан Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын журмын 6 дугаар зүйлийн 6.1-д "*Нөөц хөрөнгөөр хэрэгжүүлэх арга хэмжээг хариуцан гүйцэтгэж байгаа байгууллага, ажилтан хөрөнгийн зарцуулалтын тайланг уг арга хэмжээг хэрэгжүүлж дууссанаас хойш ажлын 15 хоногийн дотор гаргаж, тухайн шатны Засаг даргын Тамгын газарт ирүүлнэ*" гэж заасантай нийцэхгүй байна.

***Илрүүлэлт 2:*** Сумын ИТХ-ын 2025 оны Б/01 дугаар тогтоолоор 6 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр батлахдаа Төрийн хэмнэлтийн тухай хуулиар хориглосон арга хэмжээг батлуулан зарцуулсан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2-д "*төсвийн иж бүрэн, үнэн зөв байдлыг хангасан байх*", 5.1.5-д"*хариуцлагатай байх*", 6 дугаар зүйлийн 6.4-д "*Энэ хуулийн 5.1.3-т заасан санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх зарчмыг дараах байдлаар хэрэгжүүлнэ*", 6.4.1-д "*төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах*" 6.4.2-д "*төрийн болон орон нутгийн чиг үүрэгт хамаарахгүй хөтөлбөр, арга хэмжээг санхүүжүүлэхгүй байх*",Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1-д "*Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно*", 15.1.8-д "*байгууллагын төсвөөр биеийн тамир, спортын уралдаан тэмцээн зохион байгуулах*" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

***Илрүүлэлт 3:*** Орон нутгийн нөөц хөрөнгийн зардлаас уралдаан тэмцээн зохион байгуулахад зориулан 10.9 сая төгрөг олгож төсвийн хөрөнгийг зориулалт бусаар зарцуулсан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5-д "*хариуцлагатай байх*", 6 дугаар зүйлийн 6.4.1-д "*төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах*", 16 дугаар зүйлийн 16.5.2-д "*батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих*", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1-д "*Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно*", 15.1.8-д "*байгууллагын төсвөөр биеийн тамир, спортын уралдаан тэмцээн зохион байгуулах*", Сангийн сайдын 2021 оны 61 дугаар тушаалаар баталсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 1.2-д "*Энэ журмын 1.1 заасан "урьдчилан төлөвлөж төсөвт тусгах боломжгүй байсан" гэдгийг жил бүр давтагддаггүй онцгой арга хэмжээ, тохиолдлыг төсвийн зардлын зүйл, арга хэмжээний ангиллын дагуу санхүүжүүлэх боломжгүй нөхцөл байдал гэж ойлгоно*", 7.1-д "*төсвийн захирагч нөөц хөрөнгийн санхүүжилтийг зөвхөн зориулалтын дагуу зарцуулна*" гэж заасныг тус тус хэрэгжүүлж ажиллаагүй байна.

**5.3 Зөвлөмж**

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дараалаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

***Илрүүлэлт 1:*** Албан байгууллагаас ирүүлсэн хүсэлтийг шийдвэрлэн дэмжлэг олгохдоо уг байгууллагын дансаар дамжуулахгүй өөр аж ахуйн нэгж байгууллагад шилжүүлсэн байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д "*үнэн зөв байх*", Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2-д "*төсвийн иж бүрэн, үнэн зөв байдлыг хангасан байх*", 5.1.5"*хариуцлагатай байх*" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

***Өгсөн зөвлөмж:*** Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг хэрэгжүүлэн санхүүгийн ажил гүйлгээ, анхан шатны баримт үнэн зөв байх, бодитой байхад анхаарч ажиллах.

***Илрүүлэлт 2:*** Сумын ИТХ-ын 2025 оны 08 дугаар сарын 29-ны өдрийн Б/01 дугаар "Сумын 2025 оны төсвийн тодотгол батлах тухай" тогтоолоор 230.0 сая төгрөгийн 6 хөтөлбөр хэрэгжүүлэхээр батлуулсан нь Аймгийн Засаг даргын хэрэгжүүлж буй хөтөлбөртэй уялдаагүй байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.5-д "*Төсвийн ерөнхийлөн захирагчийн болон түүний эрхлэх асуудлын хүрээний агентлаг, харьяа байгууллагын хэрэгжүүлэх арга хэмжээ, ажил, үйлчилгээг тухайн төсвийн ерөнхийлөн захирагчийн хэрэгжүүлэх аль нэг хөтөлбөрт хамруулсан байна*", Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.2-т "*Аймаг, нийслэлийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг боловсруулахдаа үндэсний хөгжлийн бодлого, төлөвлөлтийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг авч, Засаг даргыг томилогдсоны дараах хоёр сарын дотор багтаан боловсруулна*" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

***Өгсөн зөвлөмж:*** Хөтөлбөр, арга хэмжээг төлөвлөхдөө  холбогдох хууль, тогтоомжтой уялдуулан ажиллах.

***Илрүүлэлт 3:*** Шилэн дансны нэгдсэн системд дараа жилийн төсвийн төсөл, хагас жилийн санхүүгийн тайлан, аудитын тайлан, дүгнэлт, зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайлан, Засгийн газрын болон орон нутгийн тусгай сангийн орлого, зарлага, хөрөнгө оруулалтын төлөвлөгөө, гүйцэтгэл, Төсвийн төвлөрүүлэн захирагчийн төсвийн хөтөлбөр, зориулалтын батлагдсан төсөв, гүйцэтгэл, Улсын төсөв болон орон нутгийн төсөвт төвлөрүүлэх орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл, Төсвийн төвлөрүүлэн захирагчийн төсвийн хөтөлбөр, зориулалтын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан тайлбар зэрэг мэдээллийг хугацаа хоцруулан байршуулсан байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3-д "т*огтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх*" гэж заасантай нийцэхгүй байна.

***Өгсөн зөвлөмж:*** Шилэн дансны тухай хуулийн  хэрэгжилтийг ханган, ажлыг чанаржуулан ажиллах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Өмнөговь аймаг дахь Төрийн аудитын газарт 2026 оны 10 дугаар сарын 01-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/сая төгрөгөөр/

| Алдаа зөрчлийн утга | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үүнээс | | | | Зөвлөмж | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Залруулсан | | Залруулаагүй | | | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Хөтөлбөр, арга хэмжээний зардлаас 2.0 сая төгрөгийн "Эко 00"-ыг байгуулан хөрөнгийн бүртгэлд тусгалгүй зардлаар хүлээн зөвшөөрч тайлагнасан. | 1 | 2.0 | 1 | 2.0 | - | - | 1 | 2.0 | - | - | - | - |
| **Дүн** | **1** | **2.0** | **1** | **2.0** | **-** | **-** | **1** | **2.0** | **-** | **-** | **-** | **-** |

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл асуудал

/сая төгрөгөөр/

| Д.д | Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
| | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | А/тушаалтны тоо | Тоо | Дүн |
| 1 | Орон нутгийн нөөц хөрөнгөөс зарцуулалт хийхдээ гүйцэтгэлийн ажлын тайлан, хөрөнгө зарцуулалтын тайлангүй 3.5 сая төгрөгийн санхүүжилт олгосон. | 1 | 3.5 | | | 1 | 3.5 | | | | | | |
| 2 | Сумын ИТХ-ын 2025 оны Б/01 дугаар тогтоолоор 6 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр батлахдаа Төрийн хэмнэлтийн тухай хуулиар хориглосон арга хэмжээг батлуулан зарцуулсан. | 1 | 40.0 | | | 1 | 40.0 | | | | | | |
| 3 | Орон нутгийн нөөц хөрөнгийн зардлаас уралдаан тэмцээн зохион байгуулахад зориулан 10.9 сая төгрөг олгож төсвийн хөрөнгийг зориулалт бусаар зарцуулсан. | 1 | 10.9 | | | 1 | 10.9 | | | | | | |
| 4 | Албан байгууллагаас ирүүлсэн хүсэлтийг шийдвэрлэн дэмжлэг олгохдоо уг байгууллагын дансаар дамжуулахгүй өөр аж ахуйн нэгж байгууллагад шилжүүлсэн. | 1 | 2.0 | | | | | 1 | 2.0 | | | | |
| 5 | Сумын ИТХ-ын 2025 оны 08 дугаар сарын 29-ны өдрийн Б/01 дугаар "Сумын 2025 оны төсвийн тодотгол батлах тухай" тогтоолоор 230.0 сая төгрөгийн 6 хөтөлбөр хэрэгжүүлэхээр батлуулсан нь Аймгийн Засаг даргын хэрэгжүүлж буй хөтөлбөртэй уялдаагүй. | 1 | - | | | | | 1 | - | | | | |
| | **Дүн** | **5** | **56.8** | | | **3** | **54.8** | **2** | **2.0** | | | | |

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

/сая төгрөгөөр/

| Д.д | Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| 1 | Шилэн дансны нэгдсэн системд дараа жилийн төсвийн төсөл, хагас жилийн санхүүгийн тайлан, аудитын тайлан, дүгнэлт, зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайлан, Засгийн газрын болон орон нутгийн тусгай сангийн орлого, зарлага, хөрөнгө оруулалтын төлөвлөгөө, гүйцэтгэл, Төсвийн төвлөрүүлэн захирагчийн төсвийн хөтөлбөр, зориулалтын батлагдсан төсөв, гүйцэтгэл, Улсын төсөв болон орон нутгийн төсөвт төвлөрүүлэх орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл, Төсвийн төвлөрүүлэн захирагчийн төсвийн хөтөлбөр, зориулалтын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан тайлбар зэрэг мэдээллийг хугацаа хоцруулан байршуулсан. | 1 | - | | | | | 1 | - |
| | | **1** | **-** | **-** | **-** | **-** | **-** | **1** | **-** |